

**МОНГОЛБАНК, САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА, САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ ХОРОО, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР, ТАГНУУЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗАР, ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР, АВЛИГАТА ТЭМЦЭХ ГАЗАР  
ХАМТРАН ГҮЙЦЭТГЭВ**

**МОНГОЛ УЛСАД МӨНГӨ УГААХ БОЛОН БУСАД  
САНХҮҮГИЙН ГЭМТ ХЭРЭГТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ  
ХУУЛЬ БУСААР АШИГЛАХ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ  
ТАЙЛАН**

**2019 ОН**

# АГУУЛГА

## Contents

### Агуулга

<b>НЭГ. ТАНИЛЦУУЛГА</b> .....	3
1.1 Хуулийн этгээдийн ил тод байдал ба эцсийн өмчлөгчийн тухай.....	3
1.2 Мөнгө угаах, терроризмтой тэмцэх Олон улсын санхүүгийн хориг хэрэгжүүлэх байгууллага (FATF)-ын зөвлөмж 24 ба 25 .....	3
1.3. Эрсдэлийн үнэлгээний зорилго.....	4
1.4. Хуулийн этгээдийн эрсдэлийн үнэлгээний тайлантай холбоотой ерөнхий мэдээлэл.....	4
<b>ХОЁР. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ</b> .....	4
2.1. Монгол улсын хуулийн этгээдтэй холбоотой зохицуулалт, ерөнхий мэдээлэл.....	4
2.2. Хуулийн этгээдийг буруугаар ашигласан типологи, жишээ.....	7
2.3. Хуулийн этгээдийг буруугаар ашигласан олон улсын жишээ .....	11
<b>ГУРАВ. ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД</b> .....	11
<b>ДӨРӨВ. ДҮГНЭЛТ</b> .....	14
4.1. Тулгамдаж буй асуудлууд.....	14
4.2. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ.....	14
4.3. Үнэлгээний хүрээнд гаргасан зөвлөмж.....	14
Ашигласан материалын жагсаалт: .....	16
Хавсралт .....	17

## НЭГ. ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Хуулийн этгээдийн ил тод байдал ба эцсийн өмчлөгчийн тухай

Аливаа хүн, хуулийн этгээд бизнесийн, арилжааны, санхүүгийн болон бусад зорилгоор үйл ажиллагаа явуулахдаа нэгдэж нийлэх нь зайлшгүй зүйл билээ. Энэ хэрэгцээ, шаардлагыг хуулийн этгээд гэдэг ойлголтоор биелүүлдэг. Өнөөгийн даяарчлагдсан нийгэм, эдийн засгийн харилцаанд янз бүрийн нэгдэх хэрэгслийг ашиглан хамтран ажиллаж байна.

Нэгдлийн хэрэгслийг (corporate vehicle) хуулийн хүрээнд хуулийн этгээд болон хуулийн хэлцэл гэж тодорхойлсон байна. Хуулийн этгээд /legal person, legal entity/ гэдэгт компани, нөхөрлөл, сан, төрийн бус байгууллага зэргийг ойлгож байгаа бол хуулийн хэлцэл гэдэгт итгэлцэл, гэрээ, төлөөлөл зэргийг хамруулан зохицуулсан байна. Хуулийн хэлцэл нь Англиас гаралтай бөгөөд энэ хэлбэр нь Монголд Улсад төдийлэн хөгжөөгүй. Харин хуулийн этгээдийг ашиглах нь Монгол Улсад түгээмэл байна.

Монгол Улсын хувьд хуулийн этгээдийг дэлхий нийтийн ашиглаж байгаа жишгээр янз бүрийн төрөл хэлбэрээр байгуулан ашиглаж байна. Дэлхий даяар хуулийн этгээдийг хууль ёсны зорилгоор ашиглахаас гадна хууль бусаар ашиглах нь мөн л түгээмэл үзэгдэл болжээ.

Хуулийн этгээдийг хууль бусаар ашиглаж гэмт хэргээс олсон бохир мөнгийг хууль ёсны мэт харагдуулах, гэмт этгээд өөрийн үйлдлээ нуун далдлах зорилгоор ашиглах байдал улам төгөлдөршиж, илрүүлэхэд маш нарийн түвэгтэй компанийн бүтэц, схем байгуулан үйлдэж байна.

Тийм учраас хуулийн этгээдийн ил тод байдал, эцсийн өмчлөгчийг тогтоох ажиллагаа зөвхөн манай улсын асуудал болоод зогсохгүй дэлхий нийтийн анхаарах асуудал болоод байна.

“Их 20” орнуудын уулзалтаар хуулийн этгээдийн ил тод байдал, эцсийн өмчлөгчийн асуудлыг онцлон хэлэлцсэн бөгөөд үүнтэй холбоотой зарчмыг гаргаж, олон улсын холбогдох байгууллагуудын гаргасан стандарт шалгуурын хэрэгжилтийг хангаж ажиллах тал дээр санал нэгдсэн байна.

### 1.2 Мөнгө угаах, терроризмтой тэмцэх Олон улсын санхүүгийн хориг хэрэгжүүлэх байгууллага (FATF)-ын зөвлөмж 24 ба 25

Монгол Улс Мөнгө угаах, терроризмтой тэмцэх Олон улсын санхүүгийн хориг хэрэгжүүлэх байгууллагын 40 зөвлөмжийн хэрэгжилтийг 2017 онд үнэлүүлсэн.

Энэхүү 40 зөвлөмжийн 24 болон 25 дугаар зөвлөмжүүдэд хуулийн этгээдийн ил тод байдал, эцсийн өмчлөгчтэй холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан бөгөөд хэрэгжилттэй холбоотой шууд гарах үр дүн дээр “хангалтгүй” гэсэн үнэлгээ авсан байна.

Тиймээс харилцан үнэлгээний тайланд дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбоотой заалтуудыг хууль журамд тусгах, хэрэгжилтийг сайжруулахтай холбоотой хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөжээ.

Зөвлөмж 24, 25-ын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор Монгол Уулс хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Эдгээрээс Улсын их хурал 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдөр Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчлэн найруулгыг баталсан бөгөөд энэхүү хуулийн заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой дагалдан гарах журмыг гаргах, батлуулах, зэрэг техникийн ажлуудууд хийгджээ.

Харин техникийн хэрэгжилтийн тайланд зөвлөмж 24-ийн 2 дугаар шалгуурт заасан “хуулийн этгээдийг буруу замаар буюу хууль бусаар ашиглах эрсдэлийг үнэлэх ажил хийгдээгүй байна.

Иймд Монгол Улсын холбогдох төрийн байгууллагууд хамтран хуулийн этгээдийг хууль бус зорилгоор ашиглахтай холбоотой эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

### **1.3. Эрсдэлийн үнэлгээний зорилго**

Энэхүү үнэлгээний зорилго нь ерөнхий 2 хэсэгт хуваагдаж байна. Үүнд:

1. Монгол Улсын сүүдрийн эдийн засгийг бүрдүүлж байгаа гэмт хэргийн орлого, түүний эх үүсвэр, бохир мөнгийг угаахдаа хуулийн этгээдийг хэрхэн ашиглаж байгаа үнэлэх;
2. Хуулийн этгээдийг хууль бусаар ашиглахтай тэмцэх үр дүнтэй арга хэмжээг авах, хувийн болон төрийн байгууллагуудын ойлголтыг нэмэгдүүлэх;

Энэхүү зорилтын хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, СМА, УБЕГ, хууль сахиулах болон бусад байгууллагууд хуулийн этгээдтэй холбоотой статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх, мөрдөн шалгасан гэмт хэрэг болон нийтлэг гарсан хууль бус үйлдлийг тодорхойлохоор хамтран ажиллалаа.

### **1.4. Хуулийн этгээдийн эрсдэлийн үнэлгээний тайлантай холбоотой ерөнхий мэдээлэл**

1.4.1. Энэхүү тайланд УБЕГ-ын статистик мэдээлэл, СМА-ны мэдээллийн бааз, хууль сахиулах байгууллагуудын мөрдөн шалгасан гэмт хэргийн мэдээллийг ашиглав.

1.4.2. Тайланд орсон хуулийн этгээдийг хууль бус үйлдэлд ашигласан жишээг хууль сахиулах байгууллагуудын мөрдөн шалгалтын баримт болон мөрдөгчдийн нийтлэг туршлагад үндэслэн гаргав. Хэдий тийм боловч хуулийн этгээдийг буруугаар ашиглах үйл ажиллагаа эдгээр типологиор хязгаарлан ойлгож болохгүй. Учир нь гэмт этгээдүүд хуулийн этгээдийн төрлийг хослуулан янз бүрийн арга техник ашиглан үйлдлээ аль болох нуун далдлах үйл ажиллагааг хийдэг.

1.4.3. Хуулийн этгээдийг буруу замаар ашиглахтай тэмцэх бусад улс орнуудын сайн жишгийг нэвтрүүлэх зорилгоор ФАТФ болон бусад олон улсын байгууллагуудын гаргасан зөвлөмж зааврыг ашиглав.

## **ХОЁР. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ**

### **2.1. Монгол улсын хуулийн этгээдтэй холбоотой зохицуулалт, ерөнхий мэдээлэл**

2.1.1. Монгол улсын хуулийн этгээдийг Улсын бүртгэлийн ерөнхий газар бүртгэдэг. Хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагааг дараах хууль тогтоомжоор зохицуулж байна. Үүнд:

❖ Улсын бүртгэлийн ерөнхий хууль

*/2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн шинэчилсэн найруулга/*

❖ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль

*/2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн шинэчилсэн найруулга/*

❖ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль

*/2018 оны 4 дүгээр сарын 26-ний өдрийн шинэчилсэн найруулга/*

❖ Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журам

*/МУ-ын Засгийн газрын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 339 дүгээр тогтоол/*

❖ Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам */МУ-ын ХЗДХСайдын 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/208 дугаар тушаал/*

❖ Олон улсын гэрээгээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллага, түүний төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэх журам

*/МУ-ын ХЗДХСайдын 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/16, А/07 дугаар*

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйлд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн төрлийг дараах байдлаар заажээ. Үүнд:

1. хуулийн этгээд шинээр үүсэн байгуулагдсаны;
2. хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсаны;
3. хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлтийн;
4. хуулийн этгээдийн үйл ажиллагаа дуусгавар болсны;
5. гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын;
6. хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын;
7. хуулийн этгээдийн тамга, тэмдгийн хяналтын дугаарын;
8. төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр хуулийн этгээдийн бүртгэлд хориг тавьсны, цуцалсны.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд улсын бүртгэлд бүртгүүлэх дараах хуулийн этгээдийг бүртгэнэ гэж заажээ. Үүнд:


1. нөхөрлөл;
2. компани;
3. холбоо /төрийн бус байгууллага/;
4. сан;
5. хоршоо;
6. шашны байгууллага;
7. нийтийн эрх зүйн хуулийн этгээд;
8. төрийн байгууллага, албан газар;
9. улсын төсөвт үйлдвэрийн газар;
10. аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар.

Мөн гадаадын хуулийн этгээд /компани, нөхөрлөл/-ийн төлөөлөгчийн газар, олон улсын гэрээ, хэлэлцээрээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллага, түүний төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэх асуудал болон улс төрийн намын бүртгэлийн асуудлаар Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд дараах байдлаар зохицуулсан байна. Үүнд:

1. Улсын бүртгэлийн байгууллага гадаадын хуулийн этгээд /компани, нөхөрлөл/-ийн төлөөлөгчийн газрыг бүртгэх бөгөөд холбогдох журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
2. Улсын бүртгэлийн байгууллага олон улсын гэрээ, хэлэлцээрээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллага, түүний төлөөлөгчийн газрыг бүртгэх бөгөөд холбогдох журмыг улсын бүртгэлийн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.
3. Энэ хуулийн 7.2, 7.3-т зааснаас бусад хэлбэрийн хуулийн этгээдийг бүртгэх харьяаллыг мөн хуулийн 8.4-т заасан журмын дагуу тогтооно.
4. Энэ хуулийн 7.1.8, 7.1.9-д олон улсын байгууллага, Засгийн газрын тусгай сан, комисс, хороо, үндэсний зөвлөл хамаарахгүй бөгөөд улсын бүртгэлд бүртгэхгүй.
5. Улсын дээд шүүх улс төрийн намыг энэ хууль болон бусад хуульд заасны дагуу бүртгэнэ.


2.1.2. Монгол улсын хуулиар нөхөрлөл, компани, холбоо /төрийн бус байгууллага/, сан, хоршоо, шашны байгууллага, нийтийн эрх зүйн хуулийн этгээд, төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг байгуулж, бүртгүүлэх боломжтой байна.

Хуулийн этгээдтэй холбоотой статистик мэдээллийг доорх хүснэгтээр харуулав. Үүнд:



Улсын бүртгэлд 2019 оны 5 дугаар сарын байдлаар бүртгэгдсэн нийт хуулийн этгээдийн 78 хувь буюу нийт 146,404 хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ байна. Нийт бүртгэлтэй ХХК-ийн 6 хувь буюу нийт 9,103 гадаадын хөрөнгө оруулалттай ХХК байна.

2.1.3. СМА-нд ирсэн Сэжигтэй гүйлгээний тайланд холбогдсон хуулийн этгээдийн төрлөөр нь ангилсан байдлыг доорх графикаар үзүүлэв.



СМА-ны мэдээллийн баазад бүртгэгдсэн хуулийн этгээдтэй холбоотой нийт СГТ-ийн 93 хувь нь ХХК-тай холбогдсон бол дөнгөж 1 хувь нь ТББ-тай холбоотой Сэжигтэй гүйлгээний тайлан байна.

Эдгээрээс харахад ХХК нь Сэжигтэй гүйлгээний тайлантай холбогдох статистик магадлал 73 хувь байна.

## 2.2. Хуулийн этгээдийг буруугаар ашигласан типологи, жишээ

### 2.2.1 Тагнуулын ерөнхий газар

**Кэйс 1.** Мөнгө угаах гэмт хэрэг тэр дундаа хууль бус мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг нуун дарагдуулахад хуулийн этгээд ашигласан жишээ.

Монгол Улсад бүртгэлтэй гадаадын хөрөнгө оруулалттай нэр бүхий ААН-ийн төгрөгийн дансанд 20 гаруй нэр бүхий валют арилжаа эрхлэгчдээс нийт 212 тэрбум гаруй төгрөг цахим гүйлгээгээр шилжүүлэгдсэн.

Тус мөнгөн хөрөнгийг дээрх ААН нь ам.долларт хувирган өөрийн ам.долларын дансанд байршуулсаны дараагаар БНХАУ-ын Засаг, захиргааны онцгой бүс Хонконгт бүртгэлтэй нэр бүхий ААН-үүд рүү тодорхой давтамжтайгаар SWIFT гүйлгээний систем ашиглан зарлагадаж байв. (Тус ААН-ийн мөнгөн хөрөнгийн шилжилт хөдөлгөөний талаарх зураглалыг Хавсралт 1-ээр хүргүүлэв)

Монгол Улсын холбогдох арилжааны банкуудын компаенсын албадаас дээрх байдлаар хийгдсэн гадаад гүйлгээний зориулалтын талаар тодруулахыг оролдоход тухайн ААН нь импортын бараа, бүтээгдэхүүн худалдан авсан төлбөр гэх байдлаар тайлбар хийсэн.

Үүний дагуу дээрх ААН-ийн холбогдох судалгааг хийхэд Хонконгт бүртгэлтэй нэр бүхий хэд хэдэн ААН-үүдтэй зуучлагч, борлуулагчаар ажиллах гэрээ байгуулсан байх бөгөөд тус гэрээнд Монгол Улсад бүртгэлтэй ААН нь борлуулагчийн үүрэг гүйцэтгэгч талаар оролцсон байв.

Судалгааны явцад дээрх Монгол Улсад бүртгэлтэй ААН-ийн нэр дээр импортын бараа, бүтээгдэхүүн бүртгэгдээгүй болохыг ГЕГ-аас тодруулсанаас гадна тус компаний дансдын мэдээлэл болон санхүүгийн баланс, татварын тайланд хийсэн дүн шинжилгээний дагуу тухайн ААН-ээс олгосон цалин, үйл ажиллагааны зардал гэх мэт үзүүлэлтүүд нь бодит байдалтай үл нийцэж байв.

Валют арилжаа хэлбэрээр дээрх ААН-ийн дансанд шилжүүлэгдсэн их хэмжээний мөнгөн хөрөнгийн талаар тодруулахад БНХАУ-аас эх үүсвэр нь тодорхойгүй мөнгөн хөрөнгө байх бөгөөд дээрх ААН-ийн валют арилжаанд оролцсон анхдагч мөнгөн хөрөнгийг бүрдүүлж байв. (Тус ААН нь Монгол Улсад эх үүсвэр нь тодорхойгүй мөнгөн хөрөнгийг хэрхэн байршуулж байгаа талаар зураглалыг Хавсралт 2-оор хүргүүлэв)

Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд Хонконгт бүртгэлтэй ААН-үүдийн үйл ажиллагааны чиглэлийг тогтоосон бөгөөд энэ нь зуучлагч, борлуулагчаар ажиллах гэрээнд заасан үйл ажиллагааны чиглэлээс зөрж байв.


Дээрх байдлаар тус ААН нь Монгол Улсын санхүүгийн системийг ашиглан эх үүсвэр нь тодорхойгүй мөнгөн хөрөнгийн хэлбэрийг өөрчлөх, эх үүсвэрийг нуун дарагдуулах цаашлаад халхавчийн компаний үйл ажиллагаа явуулж байгааг тогтоогоод байна.

Өөрөөр хэлбэл, тус халхавчийн компани нь зах зээлд бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэн түүнээс ашиг хүртэхээс илүүтэй гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэт санхүү, татварын тайлангаа бүрдүүлэн зохиомол бизнесий үйл ажиллагаа явуулж байсан.

Гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, тогтсон үйл ажиллагаатай хуулийн этгээдийн тайлан, баланстай харьцуулахад хэт зохиомол, хиймэл шинжтэй байгаа нь илт байв.

Мөн тус хуулийн этгээдийн татварын тайланд хийсэн дүн шинжилгээний дагуу үндсэн үйл ажиллагааны орлогоос үндсэн бус буюу гадаад валютын ханшийн зөрүүнээс олсон орлого хэт илүү байгаа нь сэжиг төрүүлж байв.

Тус хуулийн этгээд нь хэрхэн гарал үүсэл нь тодорхойгүй мөнгөн хөрөнгийг МУ-ын санхүүгийн системд байршуулан түүний эх үүсвэр, хэлбэрийг нуун дарагдуулан гадаад улс руу шилжүүлэх боломжтой, шилжүүлж байсан зураглалыг Схем 2.2.3-аар харуулав.



- 1** - Эх үүсвэр нь тодорхойгүй мөнгөн хөрөнгийн эзэмшигч юань шилжүүлэх гэж буй талаар мэдэгдэнэ
- 2** - Тарилан, хөдөө аж ахуйн банкны данс руу юанийг шилжүүлнэ
- 3** - халхавчийн компани валют арилжаа эрхлэгчидэд тэдний БНХАУ-ын данс руу юань шилжүүлэх гэж байгаа талаар мэдэгдэнэ
- 4** - халхавчийн компани валют арилжаа эрхлэгчидийн БНХАУ-ын данс руу юань шилжүүлнэ
- 5** - Юаний зөрүү валютыг халхавчийн компанийн МУ дах төгрөгийн данс руу шилжүүлнэ
- 6** - халхавчийн компани тухайн мөнгөн хөрөнгийг ам.доллар хөрвүүлэн Хонконгийн нэр бүхий ААН-үүд рүү шилжүүлнэ
- 7** - Эх үүсвэр нь тодорхойгүй мөнгөн хөрөнгийн эзэмшигч мөнгөн хөрөнгийг эргүүлэн нэгтгэнэ



## 2.2.2. Авлигатай тэмцэх газар


**Кэйс 2.** Монгол Улсын аж ахуйн нэгж Төрийн өмчит үйлдвэрийг газраар баталгаа гаргуулж нийт 100 гаруй сая ам.долларын гэрээ байгуулан гадаад улсын банкнаас зээл авсан.

Манай улсын ААН нэгж зээл авах цаг хугацаанд гадаад улсын банкны эрх бүхий 8 албан тушаалтан нар манай улсад гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай компани /COMPANY 1/-г үүсгэн байгуулсан.

Уг ААН-ийг үүсгэн байгуулахаас 3 сарын өмнө арилжааны банканд ААН-ийн нэр дээр данс нээж хөрөнгө оруулагч тус бүрээс 100.000 ам.долларыг свифт гүйлгээгээр шилжүүлсэн байдаг.

Монгол Улсад ААН үүсгэн байгуулах үйл ажиллагааг тухайн гадаад улсын банканд ажиллаж байгаад зөвлөх үйлчилгээ үзүүлэх болсон этгээд болох “С” зохион байгуулсан бөгөөд өөрийн оруулах хувь, мөнгөн гүйлгээг Монгол Улсад үүсгэн байгуулсан /COMPANY 2/-оос шилжүүлсэн.

COMPANY 1 арилжааны 2 банканд тоот дансуудад гадаад улсын иргэд эх үүсвэр нь тодорхойгүй их хэмжээний мөнгөн гүйлгээг төвлөрүүлсэний дараагаар олон төрлийн харилцах, хадгаламжийн данснуудыг нээж хууль бус эх үүсвэрийг өөрчилж зөвлөх үйлчилгээ үзүүлэх болсон этгээд болох “К”-ийн хуулийн этгээдүүд рүү онлайн, интернет гүйлгээг хийж анх төвлөрүүлсэн мөнгөн дүнгээс их хэмжээний зөрүүтэй гүйлгээнүүдийг гадаад гуйвуулгаар шилжүүлсэн.



### 2.2.3. Цагдаагийн байгуулага

**Кэйс 3:** Цагдаагийн байгууллагад Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанаас Монгол Улсын иргэд гадаад улсын иргэдтэй бүлэглэн зохион байгуулалттайгаар мөнгө угаах гэмт хэрэг үйлдэж байж болзошгүй талаар сэжигтэй гүйлгээний мэдээллийг ирүүлсэн.

Үүний дагуу Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газраас 18.6 дугаар зүйлийн 2.2.1 дэх хэсэг “Мөнгө угаах”, 26.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Цахим мэдээллийн хэрэгсэлд хууль бусаар халдах” гэмт хэргүүд үйлдэгдсэн үндэслэлээр хэрэг бүртгэлтийн хэрэг нээж мөрдөн шалгах ажиллагааг явуулахад


Монгол Улсын иргэн Г, А, Х нар нь гадаад улсын иргэн Э-тэй хамтран 2018 оны 06 дугаар сараас 2018 оны 12 дугаар сарын хооронд Гадаад улсад үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдтэй ижил нэртэй 16 аж ахуйн нэгж Монгол Улсад үүсгэн байгуулж, и-мэйл явуулж Бүгд Найрамдах Энэтхэг, Гренланд, Бүгд Найрамдах Турк Улс, Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Итали зэрэг улсуудаас нийт 1,142.383 евро, 99,889 ам.доллар буюу 3,6 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээтэй валютыг Монгол Улсын Голомт банкаар дамжуулан хүлээн авсан болох нь тогтоогдсон.

Мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд гэмт хэрэг үйлдэх замраар олсон мөнгийг хэрхэн хувиргасан болохыг шалгаж санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг явуулахад Монгол Улсын иргэн А, Г нар нь өөрсдийн нэр дээр 714,000,000 төгрөгийн үнэлгээтэй 2 ширхэг орон сууц, 2 граш худалдан авч, мөнгийг хувиргасан үйлдлийг тогтоож, А, Г нарын нэр дээр худалдан авсан 2 ширхэг орон сууцны шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах таслан сэргийлэх арга хэмжээг авсан байна.

Мөн нэр бүхий этгээдүүд нь гэмт хэрэг үйлдэж олсон мөнгөөр гуравдагч этгээдийн нэр дээр Ашигт малтмалын орд газрын 1 лиценз худалдан авсан болох нь тогтоогдоод байна.

Тухайн хэрэгт гадаад улсаас мэдээлэл авах хүсэлтийг интерполын шугамаар 4 улс руу, Эгмонтын шугамаар 2 улс руу нийтдээ 6 удаагийн хүсэлтийг илгээж, 3 хүсэлтэд хариу авч, 3 хүсэлтийн хариу ирээгүй хүлээгдэж байна. Мөн эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний дагуу Турк Улсад 1 хүсэлтийг илгээгээд байна.

Тус хэрэгт одоо мөрдөн байцаалтын шатанд мөрдөн шалгах ажиллагаа явагдаж байна.



### 2.3. Хуулийн этгээдийг буруугаар ашигласан олон улсын жишээ

Хууль бусаар олсон орлогоо нуух, хэлбэр дүрсийг нь өөрчлөх замаар хуулийн этгээдийг бусад улс оронд хэрхэн ашиглаж буй талаар дараах жишээг авч үзье.

#### 2.3.1. ОХУ

ОХУ-ын эрх бүхий байгууллага А компаниас АНУ-д байрлах Б компани уруу 300 сая рубль (11 сая ам.доллар) шилжүүлсэн тухай мэдээлэл авчээ. Энэ асуудлаар нэгэн улс төрийн албан тушаалтныг сэжигтнээр татсан бөгөөд түүний эхнэрийн эзэмшил, удирдлагад АНУ-д байрлах Б компани байсан нь тогтоогдсон байна. Дээрх их хэмжээний гүйлгээ хийсэн өдөр Б компани 11 сая ам.долларыг зээл нэрийдлээр Киприйн банкаар дамжуулан В компанид шилжүүлсэн. Үүний дараа В компани Франц улсад үл хөдлөх хөрөнгө худалдаж авахаар Г компанид 11 сая ам.доллороос их хэмжээний мөнгийг шилжүүлжээ. Г компани 12 сая ам.доллараас их хэмжээний мөнгийг Францын нотариатын товчоонд шилжүүлж мөнгөний гарал үүслийг нуух, хэлбэр дүрсийг нь өөрчлөхийг оролдож байв. Дээрх гүйлгээг Франц улсад салбартай Люксембург улсын хяналтын байгууллага илрүүлсэн бөгөөд тус улсын улс төрийн албан тушаалтны эхнэрийн зарцуулсан хөрөнгө ОХУ-ын төсвийн хөрөнгө байсан байна.

#### 2.3.2. Турк

Цахим ерөнцөөр мөрий тавих зориулалт бүхий хуудсыг нээн ажиллуулж байсан хэсэг бүлэг хувь этгээдүүдийг Турк улс илрүүлсэн бөгөөд тэд бусдын мэдээллийг ашиглан дээрх цахим хуудсыг нээсэн. Дээрх мэдээллийг ашиглан хуурамч компани нээн тухайн компанийн дансанд мөрийнд цугларсан мөнгийг байршуулан АТМ-аас бэлэн мөнгө болгон авдаг байв.

#### 2.3.3. Фижи

Иргэн Г нь өөрийн эзэмшдэг компаниар дамжуулан их хэмжээний мөнгө угаасан үйлдэл илэрчээ. Тэрээр үл хөдлөх хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхэлдэг компани байгуулж хиймэл худалдан авалт нэрийдлээр өөрийн эхнэрийн нэр дээрх компанид шилжүүлжээ.

#### 2.3.4. Хорват

Хорватын А компани Б компаниас үл хөдлөх хөрөнгө худалдан авсан тухай хуурамч гүйлгээ хийсэн байна. А компанийн үүсгэн байгуулагч нь Д улсын өөр компанитай холбоотой байсан ба тус улсын иргэн К нь авлигалын мөнгийг Б компанид А компанийн зээлийн эргэн төлөлт нэрийдлээр шилжүүлжээ.

Хорватын тагнуулын албаны шалгалтаар дээрх үйлдлийн эцсийн өмчлөгч нь Д улсын иргэн К байжээ.

### **ГУРАВ. ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД**

Улсын бүртгэлийн багц хуулийг 2018 онд шинэчлэн баталсан.

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлд Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг нээлттэй, хаалттай, хязгаартай өгөхөөр заасан бөгөөд хуулийн этгээдийн дараах мэдээллийг нээлттэй олгохоор заасан.

- хуулийн этгээдийн нэр;
- хаяг;
- регистрийн дугаар;
- төрөл;
- хэлбэр;

- үйл ажиллагааны чиглэл;
- улсын бүртгэлд бүртгэсэн огноо;
- үүсгэн байгуулагчийн нэр, тоо;
- хувьцаа эзэмшигчийн нэр;
- итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн нэр;
- хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан мэдээлэл;
- татан буугдсан мэдээлэл.

Хуулийн этгээдийн бусад мэдээллийг хязгаартайгаар буюу иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрлөөр, эсхүл хуулиар тусгайлан эрх олгосон байгууллагын эрх бүхий албан тушаалтны хүсэлтийн дагуу олгоно.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын <http://opendata.burtgel.gov.mn/> цахим хуудсанд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дээр дурдсан нээлттэй мэдээллийг байршуулсан.

Хуулийн этгээдийн мэдээлэл нээлттэй болсноор иргэн, хуулийн этгээд аливаа гэрээ, хэлцэл байгуулахдаа нөгөө талынхаа /хэрэв хуулийн этгээд бол/ мэдээллийг нээлттэй авах боломжтой болсон.

Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалаар “Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам”, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн А/420 дугаар тушаалаар “Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээлэл /УБ-12 маягт/”-ын загварыг тус тус батлуулан үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон түүний хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн талаарх мэдээллийг хуулийн этгээдийн хувийн хэрэгт хадгалах, уг мэдээлэлд орсон өөрчлөлтийг бүртгэх, шинээр хуулийн этгээдийг үүсгэн байгуулагч этгээд нь дээрх мэдээллийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл /хүсэлт/-д заавал тусгах талаар тусгасан. Уг зохицуулалт 2020 оны 1 сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчлэх юм.

Татварын ерөнхий хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн хуулийн этгээд эцсийн өмчлөгчийн мэдээллийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх зохицуулалт туссан.

2019 оны 6 сарын 4-ний өдрийн байдлаар 408 ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн “эцсийн эзэмшигч” хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн байна.

Мөн хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг 2020 оноос бүртгэхтэй холбоотойгоор хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим сан, програм хангамжийн хөгжүүлэлтийг хийж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.12-т “Төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журмыг холбогдох Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар батална.” гэж заасан бөгөөд Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар “Төрийн болон бусад байгууллага цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”-ыг баталсан.

Уг журам батлагдсанаар Улсын бүртгэлийн ерөнхий газар иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн сангийн холбогдох мэдээллийг Үндэсний дата төвд байршуулах ба төрийн болон бусад байгууллага Улсын бүртгэлийн ерөнхий газартай гэрээ байгуулсны үндсэн дээр вэб сервис хэлбэрээр өөрт шаардлагатай улсын бүртгэлийн мэдээллийг ашиглах боломжтой болсон.

Холбогдох эрх бүхий байгууллагууд буюу Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг байгууллагууд “Мэдээлэл солилцох гэрээ” байгуулан улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангаас хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч болон бусад мэдээллийг цахим хэлбэрээр авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Дүр эсгэн байгуулсан хуулийн этгээдийн тоог бууруулах /X тайлан өгдөг, идэвхитэй үйл ажиллагаа явуулдаггүй г.м/ болон хууль тогтоомж зөрчиж хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн хуулийн этгээдийн улсын бүртгэлд Улсын бүртгэлийн газраас хяналт шалгалтыг тогтмол хийж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий хууль шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан 2019.04.04-ний өдрийн Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын А/289 дүгээр тушаалаар “Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд УБЕГ-ын Хяналт, шалгалтын газраас **хуулийн этгээдийн улсын бүртгэлд** байнгын болон сар бүрийн түүвэрчилсэн шалгалтыг төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн гэсэн төрөлтэйгөөр хийж байна.

Тухайлбал, төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд УБЕГ-ын 2018 оны А/436 дугаар тушаалаар Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн зарим үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт шалгалт хийх Ажлын хэсэг байгуулан ажиллуулсан.

Шалгалтаар 2018 оны 1 дүгээр сарын 02-ны өдрөөс мөн оны 12 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар тус газарт бүртгэгдсэн 438 гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн улсын бүртгэлийг хянасан.

Илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх зорилгоор зарим хуулийн этгээдийн улсын бүртгэлийг түдгэлзүүлэх, холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах, буруутай албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах зэрэг арга хэмжээг авсан.

Энэхүү шалгалтын мөрөөр 139 хуулийн этгээдийн улсын бүртгэлийг хүчингүй болгож шийдвэрлэн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудсаар мэдээлсэн болно.

Мөн банкны баримт, гаалийн мэдүүлгийг хуурамчаар үйлдсэн асуудлууд гарсантай холбогдуулан Гаалийн ерөнхий газар, Монгол банкны Санхүүгийн мэдээллийн албатай хамтран ажиллахаар болсон. Цаашид дундын мэдээллийн сан үүсгэн хамтран ажиллахаар төлөвлөж байна.

Татварын ерөнхий газар болон Улсын бүртгэлийн ерөнхий газраас хамтарсан ажлын хэсэг байгуулж хуулийн этгээдийн бүртгэлийн баазын мэдээллийг татвар төлөгчийн бүртгэлийн баазын мэдээлэлтэй тулгах, бүртгэлийн үнэн, зөв байдлыг ханган ажилласан.

Хамтарсан ажлын хэсгийн хүрээнд татвар төлөгчдийн бүртгэлийн зөрүүтэй байдлыг олж тогтоон, зөрүү үүссэн шалтгаан нөхцөлийг тодорхойлж, зөрүүтэй байдлыг арилгах ажлыг хийж гүйцэтгэж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт Санхүүгийн тайлангаа найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад илгээж баталгаажуулаагүй хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хамаах талаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн улсын бүртгэлийн байгууллага өөрийн цахим хуудсаар нийтэд зарлах бөгөөд зарласнаас хойш 6 сарын дотор бичгээр санал, гомдол гаргаагүй, дампуурлын хэрэг үүсгээгүй, санхүүгийн тайлангаа гаргаагүй, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон өр, төлбөргүй бол уг хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасахаар заасан байгаа.

## **ДӨРӨВ. ДҮГНЭЛТ**

### **4.1. Тулгамдаж буй асуудлууд**

Хуулийн этгээдийг хууль бус зорилгоор ашиглах явдал цөөнгүй гарч байна. Тэр дундаа орчин үеийн шинэ техник, технологи, арга хэрэгсэл, хуулийн этгээдийн хэлбэр зэргийг оролцуулж, илрүүлэхэд маш түвэгтэй бүтэц, зохион байгуулалтанд орж мөнгө угаах зэрэг гэмт хэрэг үйлдэх нь олширчээ. Дэлхий дахинд гарч буй энэ төрлийн гэмт хэргийн зохион байгуулалт нь Монгол Улсад ч мөн адил учирч болох эрсдэлтэй байна.

Тиймээс энэ чиглэлээр цаашид арга хэмжээ авч бодитой учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэн даруй авах шаардлагатай байна.

Монгол Улсын хувьд хуулийн этгээдийг буруу замаар ашиглахтай холбоотой эрсдэлийн үнэлгээг анх удаагаа хийж гүйцэтгэлээ. Энэхүү үнэлгээнд УБЕГ-т бүртгэлтэй хуулийн этгээдийн тоо баримт, СМА-ны СГТ-тай холбоотой мэдээлэл, болон хууль сахиулах байгууллагуудын мөрдөн шалгасан гэмт хэрэгт хуулийн этгээдийг буруу замаар ашигласан мэдээллийг цуглуулж ашиглав.

Эрсдэлийн үнэлгээнд ашигласан тоо, мэдээлэл болон мөрдөн шалгасан гэмт хэргээс гарч байгаа үр дүнг дараах бүлэгт оруулав. Гэсэн хэдий ч эрсдэлийн үнэлгээг сайжруулахтай холбоотой дараах тулгамдсан асуудлууд байна. Үүнд:

1. Эрсдэлийн үнэлгээг ашигласан тоо мэдээллийн баазыг сайжруулах;
2. Эрсдэлийн үнэлгээг хийхийн ач холбогдлыг эрх бүхий байгууллагууд болон хувийн байгууллагуудад ойлгуулах;
3. Эрсдэлийн үнэлгээг цаашид дүнтэй ашиглах, хуулийн этгээдийг буруугаар ашиглахтай холбоотой хийсэн бусад орнуудын эрсдэлийн үнэлгээг судлах;
4. Олон улсын холбогдох байгууллагаас хуулийн этгээдийн эрсдэлийн үнэлгээг хийхтэй холбоотой зөвлөмж, техник туслалцаа авах;
5. ФАТФ болон АНДББ-ын типологи жишээтэй танилцах, ялангуяа “хуулийн этгээдийн ил тод байдал ба эцсийн өмчлөгч” болон “Эцсийн өмчлөгчийг нуух”-тай холбоотой ФАТФ-аас гаргасан зөвлөмж, сайн туршлагыг судалж, шаардлагатай арга хэмжээг авах;

### **4.2. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

Монгол Улсад хуулийн этгээдийг хууль бус зорилгоор ашиглаж гэмт хэрэг үйлдэх явдал нилээд түгээмэл болсон байна.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийг ихэнх хувьд хуулийн этгээдийг ашиглажээ. Тэр дундаа мөнгөн гуйвуулга, төрийн өмчит компанийн хэлбэрийг ашиглан хуулийн этгээдийн олон давхар хэлхээ бүхий бүтцийг үүсгэж эцсийн өмчлөгчийг нуун далдлах замаар хуулийн этгээдийг ашигласан, гадаад улсын иргэн хуулийн этгээд Монгол Улсын иргэн, хуулийн этгээдтэй хамтран хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг ашиглан хууль бус үйлдсэн кэйсүүд гарсан байна. Эдгээрийг энэхүү эрсдэлийн үнэлгээний тайланд онцлон тусгав.

Цаашид холбогдох эрх бүхий байгууллагаас энэхүү эрсдэлийн үнэлгээний тайлангийн чанарыг сайжруулж, тодорхой хугацааны давтамжтайгаар үнэлгээг хийх шаардлагатай. Ингэснээр хуулийн этгээдийн буруу замаар ашиглаж байгаа байдалтай тэмцэхэд шаардлагатай нөөц бололцоог зөв хувиарлах, МУТС гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхэд чухал ач холбогдолтой юм.

Түүнчлэн эрсдэлийн үнэлгээний тайланг тарааж, таниулах, зөв зохистой ашиглах чиглэлээр арга хэмжээ авч бодитой үр дүн гаргах шаардлагатай.

### **4.3. Үнэлгээний хүрээнд гаргасан зөвлөмж**

**Зөвлөмж 1.** УБЕГ-ын хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой мэдээллийн санг сайжруулах чиглэлээр төрийн бусад байгууллагууд хамтран ажиллах;

**Зөвлөмж 2.** УБЕГ-ын мэдээллийг хууль сахиулах болон төрийн эрх бүхий байгууллагууд үр дүнтэй ашиглах тогтолцоог бүрдүүлэх зорилгоор хамтын ажиллагааг сайжруулах;

**Зөвлөмж 3.** Хуулийн этгээдийг хууль бус зорилгоор ашиглахтай холбоотой эрсдэлийн үнэлгээг 2020 оны эхний хагаст багтаан дахин хийх, эрсдэлийн үнэлгээг хийхтэй холбоотой зохицуулалтыг бий болгох;

**Зөвлөмж 4.** УБЕГ хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг бүртгэхтэй холбоотой зохицуулалтыг бий болгох, улсын бүртгэгчийг чадавхижуулах;

**Зөвлөмж 5.** Хууль сахиулах байгууллагууд хуулийн этгээдийг буруугаар ашигласантай холбоотой типологи жишээг баяжуулж, дараагийн тайлан болон бусад эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

**Зөвлөмж 6.** Хуулийн этгээдийг буруугаар ашиглахтай тэмцэх, эрсдлийг бууруулах чиглэлээр олон улсын сайн туршлагыг судалж, тогтолцоог сайжруулах;

**Зөвлөмж 7.** Энэхүү тайланд тусгагдсан хуулийн этгээдийг буруу замаар ашигласан кэйс жишээнд гарсан асуудлыг шийдвэрлэх чиглэлээр арга хэмжээ авч тайлан гаргах.

*Ашигласан материалын жагсаалт:*

1. AUSTRAC 2015. Strategic Analysis PEP, Дараах холбоосоос авав: <http://www.austrac.gov.au/sites/default/files/sa-brief-peps.pdf>
2. OSCE 2012. МУТСТ эрсдэлийн үнэлгээний өгөгдөл цуглуулах гарын авлага, Дараах холбоосоос авав: <https://www.osce.org/eea/96398?download=true>
3. Strategic analysis 2019. Стратеги шинжилгээний тайлан, СМА, Монгол Улс
4. FATF – Egmont Group (2018), Concealment of Beneficial Ownership , FATF, Paris, France, [www.fatf-gafi.org/publications/methodandtrends/documents/concealment-beneficial-ownership.html](http://www.fatf-gafi.org/publications/methodandtrends/documents/concealment-beneficial-ownership.html)
5. FATF (2014). Transparency and Beneficial ownership, FATF, Paris, France, <http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/Guidance-transparency-beneficial-ownership.pdf>
6. WB (2011). The Puppet master, Stolen Asset Recovery Initiative, Washington DC, USA



Хүснэгт 1. Хуулийн этгээдийн бүртгэлийн статистик мэдээлэл

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		ДҮН	ХУВЬ
<b>Улсын бүртгэлд бүртгэлтэй нийт хуулийн этгээд</b>		<b>187,300</b>	<b>100.0</b>
Хувьцаат компани		296	0.158
Хязгаарлагдмал хариуцлагатай компани		146,404	78.166
Үүнээс:	Гадаадын хөрөнгө оруулалттай	9103	4.860
<b>Төрийн бус байгууллага</b>		<b>20,947</b>	<b>11.184</b>
<b>Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар</b>		<b>76</b>	<b>0.041</b>
<b>Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар</b>		<b>349</b>	<b>0.186</b>
<b>Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар</b>		<b>4,815</b>	<b>2.571</b>
<b>Нөхөрлөл</b>		<b>4,780</b>	<b>2.552</b>
Үүнээс	Гадаадын хөрөнгө оруулалттай	8	0.004
Хоршоо		3,949	2.108
Хадгаламж, зээлийн хоршоо		530	0.283
Сан		1,525	0.814
Үйлдвэрчний эвлэлийн байгууллага		1,395	0.745
Шашны байгууллага		525	0.280
Хэвлэл мэдээллийн байгууллага		1,074	0.573
Боловсрол, сургалтын байгууллага		632	0.337
Эрдэм шинжилгээний байгууллага		2	0.001
Засгийн газрын хоорондын байгууллага		1	0.001
<b>Татан буугдаж улсын бүртгэлээс хасагдсан хуулийн этгээд</b>		<b>12,697</b>	<b>6.779</b>

Хүснэгт 2. Хуулийн этгээдийн СГТ-тай холбогдсон байдал

Хуулийн этгээдийн төрөл	Нийт СГТ тоо	СГТ-д холбогдсон хуулийн этгээд хувь
Төрөл тодорхойгүй	27	4
ББСБ	11	2
ХЗХ	1	0
ХК	2	0
ТББ	9	1
ХХК	622	93
<b>НИЙТ</b>	<b>672</b>	<b>100</b>